



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 46

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 06 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2, 4 дүгээр зүйлийн 4.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арваннэгдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулсан 2,170,858,848 /хоёр тэрбум нэг зуун далан сая найман зуун тавин найман мянга найман зуун дөчин найман/ төгрөгийн өртөг бүхий Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам /2.8 км/-ыг Хот тохижуулах газрын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хот тохижуулах газрын дарга (Д.Очбадрах)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ОДЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн
46 дугаар тогтоолын хавсралт

Хот тохижуулах газрын үндсэн хөрөнгөд бүртгэх хөрөнгийн мэдээлэл

д/д	Хөрөнгийн нэр	Хүчин чадал		Ашиглалтад орсон огноо	Тоо ширхэг	Бүртгэх дүн
		Хэмжих нэгж	Биет хэмжээ			
1	Аймгийн төвийн хагуу хучилттай авто зам	км	2.8	2021	1	2,170,858,848
Дүн						2,170,858,848 /хоёр тэрбум нэг зуун далан сая найман зуун тавин найман мянга найман зуун дөчин найман/ төгрөг